



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/408

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 4.1, Засаг даргын зөвлөлийн 2023 оны 05 дүгээр сарын 03 ны өдрийн 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арбулаг сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэж сумын төвийн гүн өрмийн худаг хөлдөж, ус гарахгүй болсонтой холбогдуулан худаг засварын ажилд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Худаг засварын ажилд шаардлагатай 11,475,000 (Арван нэгэн сая дөрвөн зуун далан таван мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ